

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2024 оны 03 сарын 25 өдөр

Дугаар: 07

Улаанбаатар хот

Компанийн жилийн үйл ажиллагааны болон
санхүүгийн тайланг дүгнэх тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11, 80 дугаар зүйлийн 80.2, 96 дугаар зүйлийн 96.5, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.9, 24 дүгээр зүйлийн 24.3, "Грант торнтон аудит" ХХК-ийн 2024 оны 02 дүгээр сарын 20-ны өдрийн хараат бус аудиторын дүгнэлт, Сангийн сайдын 2017 оны 01 дүгээр тушаалаар батлагдсан "Үндэсний давхар даатгал" ХК-ийн дүрмийн 4.2.3, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан "Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ын 3.3.18-д заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Грант торнтон аудит" ХХК-ийн хараат бус аудиторын тайлан, дүгнэлтийг үндэслэн "Үндэсний давхар даатгал" ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна гэж дүгнэсүгэй.
2. Компанийн санхүү, үйл ажиллагаандаа холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Жавхлант)-д үүрэг болгосугай.
3. Энэхүү дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж батлуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Ч.Тавинжил)-д даалгасугай.
4. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо (Ц.Дашдондог)-нд үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.ТАВИНЖИЛ